

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/44/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Балжинням

Утас: 70433061

цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудитхийсэнцэвэрхөрөнгө/өмчийнөөрчлөлтийнтайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3.Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	Error! Bookmark not defined.
4.1 Албан шаардлага	
4.2 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,672,993.00</u>	<u>27,253,635.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	13,780,820.00	27,253,635.00
354	Хангамжийн материал	13,780,820.00	27,253,635.00
35410	Бичиг хэргийн материал	362,200.00	962,515.00
35420	Аж ахуйн материал	10,010,500.00	5,821,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	122,000.00	502,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,286,120.00	19,967,620.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,751,620,442.34</u>	<u>1,348,081,661.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,751,620,442.34	1,348,081,661.26
392	Биет хөрөнгө	1,671,749,192.30	1,268,332,161.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	669,887,215.06	570,842,015.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(255,582,342.76)	(213,297,386.84)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	519,623,791.00	245,223,966.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(310,329,391.36)	(177,982,632.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,708,000.00	23,283,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,987,717.20)	(22,421,399.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,025,673.00	9,025,673.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,565,713.24)	(8,435,693.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,600,942,562.00	1,600,942,562.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(555,972,884.20)	(758,847,942.16)
393	Биет бус хөрөнгө	79,871,250.04	79,749,500.08
39301	Програм хангамж	487,000.00	487,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(121,749.96)	(243,499.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	79,506,000.00	79,506,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,776,293,435.34</u>	<u>1,375,335,296.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8,175,194.00</u>	<u>888,576.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,175,194.00	888,576.00
413	Өглөг	8,175,194.00	888,576.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	888,576.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,150,048,643.34</u>	<u>1,374,446,720.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,150,048,643.34	1,374,446,720.26

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	618,069,598.00
51101	Өмч: - төрийн		618,069,598.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,145,174,819.44	751,503,298.36
51210	Өмнөх үеийн үр дүн	1,145,174,819.44	1,143,496,819.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	(391,993,521.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,873,823.90	4,873,823.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,158,223,837.34	1,375,335,296.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	538,423,646.00	468,456,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	34,918,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	34,918,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	34,918,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого		34,918,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,423,646.00	433,538,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,360,400.00	318,508,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,360,400.00	318,508,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,730,800.00	15,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,179,700.00	99,179,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	99,179,700.00	99,179,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	760,365,873.64	760,049,154.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,365,873.64	760,049,154.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,743,126.64	703,245,583.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,027,419.00	153,925,485.00
210101	Үндсэн цалин	212,027,419.00	153,925,485.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,258,338.00	22,783,594.00
210201	Тэтгэврийн даатгал	19,957,164.94	15,306,345.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,201.33	1,537,285.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,587,801.05	2,592,799.45
210204	Ажилгүйдлийн даатгал	379,768.02	272,592.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,222,402.66	3,074,571.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,225,246.00	74,243,238.00
210301	Гэрэл, цахилгаан	65,710,246.00	74,188,238.00
210303	Цэвэр, бохир ус	515,000.00	55,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,893,884.00	87,764,119.00
210401	Бичиг хэрэг	921,350.00	899,809.00
210402	Тээвэр, шатахуун	39,711,040.00	27,676,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	230,500.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,938,394.00	56,561,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	327,000.00

210408	Бараа материал акталсны зардал	-	2,100,000.00
2105	Нормативт зардал	3,666,080.00	967,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	748,080.00	614,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,918,000.00	353,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,000.00	173,931.00
210604	Урсгал засвар	55,000.00	173,931.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,579,923.00	2,246,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,508,383.00	875,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	737,100.00	382,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,000.00	539,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	496,100.00	297,000.00
210807	Газрын төлбөр	88,340.00	151,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,037,236.64	361,141,976.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,582,620.00	57,234,162.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	254,454,616.64	303,907,814.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,622,747.00	56,803,571.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,612,746.00	56,803,571.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,460,000.00	695,180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,000,000.00	56,108,391.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(221,942,227.64)	(291,592,554.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	100,400,966.34
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	100,400,966.34
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(100,400,966.34)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(221,942,227.64)	(391,993,521.08)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	618,069,598.00	5,473,563.90	1,172,843,722.08	1,796,386,883.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	396,574.00	396,574.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	618,069,598.00	5,473,563.90	1,173,240,296.08	1,796,783,457.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(599,740.00)	-	(599,740.00)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(28,065,476.64)	(28,065,476.64)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	618,069,598.00	4,873,823.90	1,145,174,819.44	1,768,118,241.34
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	618,069,598.00	4,873,823.90	1,145,174,819.44	1,768,118,241.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,678,000.00)	(1,678,000.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	618,069,598.00	4,873,823.90	1,143,496,819.44	1,766,440,241.34
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(391,993,521.08)	(391,993,521.08)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	618,069,598.00	4,873,823.90	751,503,298.36	1,374,446,720.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	538,423,646.00	433,538,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,423,646.00	433,538,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,360,400.00	318,508,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,360,400.00	318,508,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,730,800.00	15,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,179,700.00	99,179,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	99,179,700.00	99,179,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	538,423,646.00	433,538,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,423,646.00	433,538,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,909,005.00	375,943,767.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,732,738.00	152,717,175.00
210101	Үндсэн цалин	193,732,738.00	152,717,175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,801,385.00	22,840,149.00
210201	Тэтгэврийн даатгал	43,554,968.07	15,362,902.17
210202	Тэтгэмжийн даатгал	869,989.79	1,537,280.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,479,696.82	2,592,798.73
210204	Ажилгүйдлийн даатгал	156,740.99	272,591.44
210205	Эрүүл мэндийн даатгал	1,739,989.33	3,074,575.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,765,246.00	74,243,238.00
210301	Гэрэл, цахилгаан	65,710,246.00	74,188,238.00
210303	Цэвэр, бохир ус	55,000.00	55,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,561,213.00	86,707,434.00
210401	Бичиг хэрэг	931,150.00	1,320,124.00
210402	Тээвэр, шатахуун	8,480,000.00	29,593,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	216,223.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	-	180,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,928,840.00	54,643,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,005,000.00	770,000.00
2105	Нормативт зардал	8,598,880.00	6,556,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	748,080.00	614,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,850,800.00	5,942,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,248,943.00	27,769,115.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,177,403.00	26,398,275.00
210803	Даатгалын үйлчилгээ	737,100.00	382,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,000.00	485,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	496,100.00	351,000.00
210807	Газрын төлбөр	88,340.00	151,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,351,100.00	5,110,156.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,351,100.00	5,110,156.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,514,641.00	57,594,833.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,579,546.00	57,594,833.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,139,800.00	1,486,442.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,287,000.00	56,108,391.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417688600.00	417688600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417688600.00	417688600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361540100.00	360093767.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	152717175.00
210101	Үндсэн цалин	0.00	152717175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	22840149.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	15362902.17
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1537280.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	2592798.73
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	272591.44
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	3074575.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	74243238.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	74188238.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	55000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	86707434.00
210401	Бичиг хэрэг	0.00	1320124.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	29593610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	200,000.00
210404	Ном, хэвлэл	-	180,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	54,643,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	770,000.00
2105	Нормативт зардал	-	6,556,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	614,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,942,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	361,540,100.00	2,004,771.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	361,540,100.00	633,931.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	382,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	485,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	351,000.00
210807	Газрын төлбөр	-	151,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,024,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,024,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,148,500.00	57,594,833.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,148,500.00	57,594,833.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,486,442.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,148,500.00	56,108,391.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	417,688,600.00	417,688,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	417,688,600.00	417,688,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	318,508,900.00	318,508,900.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	99,179,700.00	99,179,700.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121,730,800.00	25,764,344.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121,730,800.00	25,764,344.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,730,800.00	25,764,344.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,730,800.00	25,764,344.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	121,730,800.00	25,764,344.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121,730,800.00	15,850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,730,800.00	15,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,730,800.00	2,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,750,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот тохижуулах газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 02 дүгээр сарын 23-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тухайн байгууллагын эрхэм зорилго нь олон ястны өлгий нутаг Ховд хотынхоо өнгө төрөх, хөгжил дэвшил цэвэр цэмцгэр байдлыг хангаж ард иргэдийн аюулгүй, таатай амьдрах орчин бүрдүүлэхийг эрхэмлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл зорилт нь хот суурин газрын хог тээвэрлэх, ногоон байгууламжийн тохижилт, арчлалт, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг угсралт, зам талбайн тохижилт үйлчилгээ, цэвэрлэгээ зэрэг үйл ажиллагаа явуулж ард иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлэх гэж тодорхойлоод зорилтыг хэрэгжүүлэх, зорилгоо хангахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаанд Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2021 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайланг аудитад ашиглалаа.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 2529,3 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 50,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 40,6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хот тохижуулах газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 407,8 сая төгрөгөөр буюу 23 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд эхэнд авлага данс 10,8 сая, оны эцэст 1,6 сая төгрөг болж 9,2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 13,7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 27,2 сая төгрөг болж өссөн байна. Үүнд аж ахуйн материал 28,9 сая, бичиг хэргийн материал 1,4 сая, бусад хангамжийн материалд 41,3 сая, эм боох материал 0,6 сая, сэлбэг хэрэгсэл 2,9 сая, түлш шатах тослох материал 29,5 сая нийт 104,9 сая төгрөгөөр нэмэгдэж 91,4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 70,0 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 34,9 сая төгрөг бэлтгэж, 91,4 төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2912,1 сая төгрөг байсан бол оны эцэст 2529,3 сая төгрөг болж, 382,8 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй, хөрөнгө акталсантай холбоотой байна. Тайлант онд нийт 160,8 сая төгрөгийн хөрөнгө акталж, 222,7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжүүлсэн байна.

Тайлант оны эхэнд өр төлбөр данс 8,1 сая төгрөг байсан бол оны эцэст 0,8 сая төгрөг болж 7,3 сая төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1768,1 сая төгрөг, оны эцэст 1367,5 сая төгрөг тайлант онд 400,5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хот тохижуулах газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 417,6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 417,6 төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ -аас тус байгууллагын төсвийг 417,6 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 417,6 сая төгрөгийн төсөв баталснаас 318,5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 99,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 318,5, орон нутгийн хөгжлийн сангаас 99,1 сая төгрөг нийт 417,6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар өмнөх оны үндсэн үйл ажиллагааны орлогын авлага 8,9 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 14,0 сая төгрөг, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2,1 сая төгрөгийн санхүүжилт авч, 25,7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 146 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН
АУДИТОР: Д.БАЛЖИННЯМ